



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бүрэгхангай сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн
тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн ХУРААНГУЙ тайлан

Аудитын код: БУА-2024/116/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Булган аймаг

2024 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ
Утас: 70342580 Цахим хаяг: Erdene.B@audit.local
Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn
Аудитор: Б.Энхтөр
Утас: 70342716 Цахим хаяг: Enkhturb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Дүгнэлт



БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2024.02.23 № 139

танай _____ ны № _____ т

БҮРЭГХАНГАЙ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Ц.МӨНХТУЛГА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бүрэгхангай сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бүрэгхангай сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд орон нутгийн төсвөөс 740.9 сая төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлого 0.1 сая төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансаар 48.3 сая төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр 789.3 сая төгрөг зарцуулж 16.5 сая төгрөгийн төвлөрүүлсэн байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаг даргын тамгын газар дээр үйлчилгээний, хөдөө аж ахуйн, газар тариалангийн зориулалтын 29 газрын 208,745 /м.кв/ газар дээр үнэ тогтоож 417.5 сая төгрөгийн газрыг орлогоор тусгасан байна.

006020322

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	48,450,744.00	49,025,944.00
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	4,216,645,528.74	5,006,399,817.00
Нийт хөрөнгийн дүн	4,265,096,272.74	5,055,425,761.00
Нийт өр төлбөрийн дүн	3,785,379.00	1,591,812.20
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4,261,310,893.74	5,053,833,948.80
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4,265,096,272.74	5,055,425,761.00
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
Үйл ажиллагааны орлогын дүн	980,431,568.40	1,880,418,949.00
Үйл ажиллагааны зардлын дүн	994,310,216.70	1,087,125,893.94
Үйл ажиллагааны үр дүн	(13,878,648.30)	793,293,055.06
Үйл ажиллагааны бус үр дүн		16,568,633.52
Үйл ажиллагааны нийт үр дүн	(13,878,648.30)	793,293,055.06
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл		721,053,754.60
Тайлант оны үр дүн		792,523,055.06
Эцсийн үлдэгдэл		5,053,833,948.80
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	983,564,161.40	799,082,938.00
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	728,966,464.40	750,159,203.00
Үйл ажиллагааны ЦМГ	254,597,697.00	48,923,735.00
Хөрөнгө оруулалтын ЦМГ	254,597,697.00	48,923,735.00
Санхүүгийн ажиллагааны ЦМГ		
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	(254,597,697.00)	(48,923,735.00)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн		724707669.85
Урсгал зардал		675783934.85
Хөрөнгийн зардал		48,923,735.00
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		741,028,500.00
Улсын төсвөөс санхүүжих		
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас		741,028,500.00

Гурав.Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 420.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 417.6 сая төгрөгийн алдааг залрууллаа. Үүнд:

- Санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн орлого хэсэг дээр үйл ажиллагааны орлого 100.0 мянган төгрөг тусгагдаагүй байсныг тусгууллаа.
- Бүрэгхангай сумын ЗДТГ-т 29 нэгж налбар газрыг орлогоор бүртгэж баланст тусгууллаа.

5.1 Төлбөрийн акт

Хятад улсын Жинин хот руу 2023 оны 11 сард ажлын өдрүүдээр аялал зугаалга хийсэн 11 албан хаагчийн ажлын 5 өдрийн цалинг суутгасан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх,

санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэсэн заалттай нийцээгүй.

2 Албан шаардлага

Албан шаардлага бичигдээгүй болно.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.

Тус байгууллагат зөвлөмж өгөөгүй болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/												
Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээлли йг тусгахгүй орхигдуул сан		Буруу тусган илэрхийлс эн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаа гүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бүрэгхангай сумын ЗДТГ	2	417.6					2	417.6				
Дүн	2	417.6					2	417.6				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/												
Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн										
Бүрэгхангай сумын ЗДТГ	1	2.9	1	2.9								
Дүн	1	2.9	1	2.9								